



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НУБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН “ХӨТӨЛБӨРТ ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН”



2023 он
Улаанбаатар хот

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН “ХӨТӨЛБӨРТ ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Энэхүү “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны хагас жилийн Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан”-г Европын Холбооноос Монгол Улсын Засгийн газарт үзүүлж буй төсвийн дэмжлэгийн бүрэлдэхүүн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс (НҮБХХ) НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий зүйл: Энэхүү тайлан нь Европын Холбооны санхүүжилтээр боловсруулагдсан. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) нь “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техникийн туслалцааны төслийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлж байна.

Төслийн дэмжлэгийн хүрээнд Монгол Улсад бодлого ба төсвийн уялдааг хангах, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг ТХЗ-ийн тэргүүлэх салбар, хөтөлбөрүүдэд нэвтрүүлэх, дунд хугацааны зарлагын хүрээнд шилжих бодлогын хувилбарыг тодорхойлохоор ажиллаж байна. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь төслийн дэмжлэгтэйгээр 2024 оны төсвийн төслөө үр дүнд чиглэсэн зарчмуудыг баримтлан боловсруулсаны зэрэгцээ 2023 оны эхний хагас жилийн үр дүнгийн мэдээлэл бүхий төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төслийг шинэ аргачлал, маягтын дагуу гүйцэтгээд байна.

Төсвийн байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг хангах, болзошгүй эрсдэлийг удирдах, төсвийн зарцуулалтад хяналт тавих, төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн захирагч хооронд байгуулсан гэрээний үр дүнг үнэлж дүгнэхэд чиглэсэн энэхүү 2023 оны эхний хагас жилийн “Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан”-г боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажилласан “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн зөвлөх багийн бүрэлдэхүүн Б.Батбаяр, Г.Түвшинтуяа, Б.Бямбасүрэн нарт талархал илэрхийлье.

**ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ САНХҮҮ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР**

Агуулга

Удиртгал	6
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	7
Эрхэм зорилго	8
2.1 Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлангийн хураангуй	10
2.2 Хөтөлбөрийн төсвийн ерөнхий гүйцэтгэл.....	13
ХХААХҮЯ -ны 2023 оны төсвийн тухай хуулийн хүрэх үр дүнгийн тайлан:	14
“Хөдөө аж ахуй” хөтөлбөрийн үр дүнгийн тайлан.....	14
“Газар тариалан” хөтөлбөрийн үр дүнгийн тайлан.....	17
Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн үр дүнгийн тайлан.....	24
Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийн үр дүнгийн тайлан	26
Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн үр дүнгийн тайлан	26
ТХЗ-ийн үр дүнгийн тайлан	21
ХХААХҮ-ийн сайд	30
Дүгнэлт, санал	32

ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бүтэц	9
Зураг 2	Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл	10
Зураг 3	ХХААХҮЯамны 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэл	13
Зураг 4	ХХААХҮЯамны 2023 эхний хагас жилийн хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл гүйцэтгэл.....	13
Зураг 5	“Хөдөө аж ахуй” хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл	14
Зураг 6	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бодит өсөлтийн хувь -ийн гүйцэтгэл	15
Зураг 7	“Малын гоц халдварт өвчний гаралт өмнөх оноос 20-оос доошгүй хувиар буурах тохиолдлын тоо”-гүйцэтгэл	15
Зураг 8	“Газар тариалан” хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл	17
Зураг 9	“Үр тариа (цн/га)”-ийн гүйцэтгэл	18
Зураг 10	Төмс (цн/га)-ний гүйцэтгэл	19
Зураг 11	Хүнсний ногоо (цн/га)	19
Зураг 12	“Нийт хураан авсан улаан буудайнаас стандартад нийцсэн хувь”-ний гүйцэтгэл	21
Зураг 13	Хүнсний ногооны дотоодын хангамжийн хувь	22
Зураг 14	Төмсний дотоодын хангамжийн хувь	23



Зураг 15	“Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх” хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл	24
Зураг 16	Нийлүүлсэн түүхий сүү (сая литр)-ний гүйцэтгэл	24
Зураг 17	Бэлтгэж, борлуулсан махны хэмжээ (мян.тн)	25
Зураг 18	“Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх” хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл	26
Зураг 19	“Дархан арьс ширний цогцолбор” ҮТП-ын дэд бүтэц, үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын хувь	26
Зураг 20	“Шинэ Ховд” ҮТП-ын дэд бүтцийн бүтээн байгуулалтын явцын хувь	27
Зураг 21	“Жижиг дунд үйлдвэрийг дэмжих” хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл	28
Зураг 22	Идэвхтэй жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн тоо	29
Зураг 23	ХХААХҮ-ийн сайдын 2023 оны эхний хагас жилийн хөтөлбөрийн гүйцэтгэл	34
Зураг 24	ХХААХҮ-ийн сайдын 2023 оны эхний хагас жилийн хөтөлбөрийн гүйцэтгэлийн үр ашиг	35

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг бэлтгэсэн байдал	11
Хүснэгт 2	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг бэлтгэсэн байдал	12
Хүснэгт 3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн явц	12
Хүснэгт 4	2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулах нь	30



Удиртгал

Монгол Улсын Засгийн газар, Европын холбоо (ЕХ), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-өөс Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад чиглэсэн төрийн бодлого, төлөвлөлт болон төсөвлөлтийн уялдааг сайжруулах замаар үр дүн, хөтөлбөрт суурилсан төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх, тайлагнах тогтолцоо бүхий төсөв, санхүүгийн зохистой удирдлагыг нэвтрүүлэхээр 4 бүрэлдэхүүн хэсэг байгуулан ажиллаж байгаа билээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт болох Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлтийг ТХЗ-той уялдуулан баталсан.

2023 онд суурь он, суурь түвшний мэдээллийг оруулан баталсан нь үр дүнд гарах өөрчлөлтийг бодитоор хэмжиж “Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан” -г тайлагнах боломжийг бүрдүүлээд байна.

Төсвийн хуулийн дагуу Хөтөлбөр, түүний үр дүнг төсвийн зарлагаар тайлагнах байдал өнгөрсөн хугацаанд чанарын шаардлага хангахгүй байгаа тухай “Төсвийн гүйцэтгэл болон үр дүнгийн тайлагналын өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ”-нд, төлөвлөлт, төсөв, гүйцэтгэлийн уялдаа хангалтгүй байгаа тухай “Бодлогын баримт бичиг болон төсвийн уялдаа” тайланд өгсөн зөвлөмжийн дагуу “Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнг тайлагнах заавар, маягт” -ын төслийг боловсруулсан.

“Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан”-ийн зорилго нь төсвийн байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг хангуулах, болзошгүй эрсдэлийг удирдах, төсвийн зарцуулалтад хяналт тавих, төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн захирагч хооронд байгуулсан гэрээний үр дүнг үнэлж дүгнэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн үр дүнгийн тайланг гаргахад оршино.

Бидний санал болгож буй маягт, аргачлалаар 2023 оны хагас жилийн “Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан” -г ХХААХҮ-ийн сайдаас авсан бөгөөд доорх үр дүнг үзүүллээ.



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Эрхэм зорилго

Салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Стратегийн тэргүүлэх чиглэл

1. Мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалан, хүнсний болон хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, дотоод худалдаа, маркетингийн бодлого боловсруулах, тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Мал, амьтныг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчний гаралтыг тогтвортой бууруулж, тархалтыг зогсоох, өвчингүй тайван бүсийг баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлэх;
3. Малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, нөөцийг тогтоох, төлөв байдлыг үнэлэх, бүртгэх, тэдгээрийг тогтвортой ашиглах, хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтийг зохицуулах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарц, чанарыг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлж, дэмжин хөгжүүлэх;
4. Мал, амьтан, таримал ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, малын тэжээл, түүний нэмэлтийн хорио цээр, экспорт, импортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах;
5. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, усан хангамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
6. Тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, таримал ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх, тариалангийн эдэлбэр газрыг эргэлтэд оруулах, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;
7. Байгалийн гэнэтийн аюул, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах;
8. Салбарын үйлдвэрлэлд шинэ, дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, нутагшуулах, техникийн шинэчлэлийг хийх;
9. Хөнгөн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, ноос, ноолуур, арьс, ширийг гүн боловсруулах, импортыг орлох, экспортын баримжаатай сүлжмэл, нэхмэл, оёмол хувцас, арьс, ширэн бүтээгдэхүүн, хэрэгслийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
10. Хүн амын эрүүл, баталгаат хоол, хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, дотоод худалдааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах.

11. Өндөр технологийн шинэ салбаруудыг хөгжүүлэн мэдлэгт суурилсан эдийн засгийн үндсийг тавих, мэдээллийн технологийн хөгжилд нийцүүлэн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулан, шуурхай, ил тод байдлыг хангах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой бодлого, зохицуулалтыг бий болгох, хэрэгжүүлэх;
12. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засаг, төсвийн тооцоо, хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсвийн төлөвлөлт, санхүү, төсвийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллах.
13. Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангуулах, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр хангагдах, чанартай үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хяналтыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх.

Эдгээр эрхлэх асуудлын хүрээнд 2023 оны Төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар дээрх агуулгыг багцлан 5 хөтөлбөрийн 13 шалгуур үзүүлэлтийг баталсан.

ХХААХҮ-ийн сайдын 2023 оны ТЕЗ-ийн хөтөлбөрийн үр дүнд суурилсан төсвийн төсөл


Төсвийн төсөл боловсруулах Удирдамжид туршилтын яамдын үр дүнд суурилсан төсвийн төсөл боловсруулах маягт, зааврын төслийг Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага /ҮДСНУ/-ын арга зүйг ашиглан боловсруулсан. Энэхүү маягт, зааврууд нь 2023 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан байдлаар боловсруулахдаа зөвхөн тухайн хөтөлбөрийн үр дүнг салангид байдлаар тодорхойлох бус хөтөлбөрийн болон ТЕЗ-ийн үр дүнг үндэсний, салбарын бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтуудтай нягт уялдуулахад онцгойлон анхаарч байгаагаараа онцлог болсон.

Маягт, зааврын төсөл боловсруулахдаа ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн оролцогч талууд, тэдгээрийн асуудал, шалтгаан, тэдгээрийг арилгах/шийдвэрлэх стратеги, арга замыг тодорхойлон үүний үндсэн дээр хүрэх үр дүн, гарц, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох ProLL /Program Logic Linkage/ загварыг ашигласан. Энэхүү загварын дагуу үр, дүн гарцыг тодорхойлох, түүнд шаардагдах төсвийн тооцоог хийх Ажлын хүснэгт 1, 2-ыг боловсруулсан бөгөөд эдгээр хүснэгтийг бөглөж ТЕЗ-ийн болон ТЕЗ-ийн хөтөлбөрүүдийн гарц үр дүнг тодорхойлох Асуудал, Шийдлийн модны шинжилгээ хийх Зааврыг мөн боловсруулж, Төсвийн удирдамжид оруулсан. Ажлын хүснэгт 1 ба 2 дээр ажиллаж тодорхойлсон үр дүн, гарц, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, төсөв болон ТЕЗ-ийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн харуулах хүснэгтүүдийг мөн боловсруулж Удирдамжид тусгасан.

ТЕЗ-ийн тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан үр дүнд суурилсан төсвийн саналын Маягт, Ажлын хүснэгт, түүнийг бөглөх зааврын төслийг Сангийн яаманд 2022 оны 7-р сарын 3-ны өдөр эцэслэн хүргүүлсэн. Сангийн сайдын тушаалаар 2022 оны 7-р сарын 5-ны өдөр батлагдсан төсвийн төсөл боловсруулах удирдамжид дээрх маягт, зааврууд тусгагдан орсон болно.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бүтэц

Зураг 1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд




Хөтөлбөрийн ерөнхий гүйцэтгэл

2.1 Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлангийн хураангуй

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн 7 (54%) шалгуур үзүүлэлт нь үр дүндээ хүрсэн, 3 (23%) шалгуур үзүүлэлт нь сайжруулах шаардлагатай буюу 60%-100%-ийн гүйцэтгэлтэй бол 2 (15%) шалгуур үзүүлэлт нь үр дүндээ хүрээгүй, мөн 1 шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн мэдээлэл хараахан гараагүй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны хагас жилийн нийт төсөв нь 170,545.4 сая төгрөг бөгөөд үүнээс 132,065.1 сая (77%) төгрөгийн төсвийн гүйцэтгэлтэй байна.

Зураг 2. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл







Хүснэгт 1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг бэлтгэсэн байдал

Хөтөлбөр	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Гүйцэтгэлийн мэдээлэл бэлтгэгдсэн эсэх
Мал аж ахуй хөгжүүлэх	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бодит өсөлтийн хувь	4.5	Тийм
	Малын гоц халдварт өвчний гаралт өмнөх оноос 20-оос доошгүй хувиар буурах тохиолдлын тоо	370	Тийм
Газар тариалан хөгжүүлэх	Нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэх чиглэлээр:		
	Үр тариа (цн/га)	14	Тийм
	Төмс (цн/га)	130	Тийм
	Хүнсний ногоо (цн/га)	200	Тийм
	Нийт хураан авсан улаан буудайнаас стандартад нийцсэн хувь	70	Тийм
	Төмс, хүнсний ногооны дотоодын хангамжийн хувийг нэмэгдүүлэх чиглэлээр:		
	Хүнсний ногооны дотоодын хангамжийн хувь	75	Тийм
	Төмсний дотоодын хангамжийн хувь	100	Тийм
Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Мах, сүү бэлтгэлийн улирлын хэлбэлзэл бууруулах чиглэлээр:		
	Нийлүүлсэн түүхий сүү /сая литр/	15	Тийм
	Бэлтгэж, борлуулсан махны хэмжээ /мян.тн/	15	Тийм
Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх	"Дархан арьс ширний цогцолбор" УТП-ын дэд бүтэц, үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын хувь	60	Тийм
	"Шинэ Ховд" УТП-ын дэд бүтцийн бүтээн байгуулалтын явцын хувь	90	Тийм
Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	Идэвхтэй жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн тоо	65000	Үгүй

Энэ бүлэгт 2023 оны хагас жилийн хөтөлбөрийн үр дүнг харууллаа. 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтын хөтөлбөрийн үр дүнг шалгуур үзүүлэлт бүрийн гүйцэтгэлээр гаргасан. Үүнд:

Хүрсэн үр дүнгийн түвшинг эрэмбэлэх 3 түвшин, мэдээлэл дутмаг эсвэл хангалтгүйн улмаас үр дүнг эрэмбэлэх боломжгүй 1 гэсэн нийт 4 түвшний гүйцэтгэлийг оноогоор тодорхойлсон. Онооны картыг ногоон, шар, улаан, саарал өнгөнд хуваарилан дараах байдлаар ашиглав.

Хүснэгт 2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг бэлтгэсэн байдал

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл	
	100%-аас дээш хувийн гүйцэтгэлтэй хөтөлбөрүүд
	60%-100%-ийн гүйцэтгэлтэй хөтөлбөрүүд
	0%-60%-ийн гүйцэтгэлтэй хөтөлбөрүүд
	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн мэдээлэл нь хараахан бэлтгэгдээгүй.

Хүснэгт 3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн явц

Хөтөлбөр	Үр дүндээ хүрсэн	Сайжруулах шаардлагатай	Үр дүндээ хүрээгүй	Мэдээлэл дутуу
Мал аж ахуй хөгжүүлэх	2			
Газар тариалан хөгжүүлэх	3	3		
Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	2			
Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх			2	
Жижиг дунд үйлдвэрийг дэмжих				1
Нийт	7	3	2	1


2.2 Хөтөлбөрийн төсвийн ерөнхий гүйцэтгэл

Зураг 3. ХХААХҮ-ийн сайдын 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэл



ХХААХҮ-ийн сайдын 2023 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлээр нийт орлого 192,607.5 сая төгрөг буюу 87.7 хувийн биелэлттэй, нийт зарлага 132,065.1 сая төгрөг буюу 77.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан. (Зураг 3).

Зураг 4. ХХААХҮ-ийн сайдын 2023 эхний хагас жилийн хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл




ХХААХҮ-ийн сайдын 2023 оны төсвийн тухай хуулийн хүрэх үр дүнгийн тайлан:


“Хөдөө аж ахуй” хөтөлбөрийн үр дүнгийн тайлан

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд “Мал аж ахуй” хөтөлбөрийн үр дүнгийн дараах хоёр (2) шалгуур үзүүлэлт батлагдсан.

Зураг 5. “Мал аж ахуй” хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Зураг 6. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бодит өсөлтийн хувь -ийн гүйцэтгэл



Ахиц дэвшил: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого, хууль эрх зүйн шинэчлэл, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөөг илэрхийлэх нэгдсэн үр дүнг дээрх үзүүлэлтээр тодорхойлсон ба 2023 оны эхний хагас жилийн байдлаар 12 хувийн өсөлттэй байна. Дээр өсөлтөд 2023 онд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн шинэчлэл, гааль, НӨАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт болон Засгийн газраас 13 хувийг хариуцан төлөх нөхцөлтэй хөтөлбөрийн зээлүүд голчлон нөлөөлсөн гэж үзэж байна.

Хүндрэл, бэрхшээл: Үр дүнгийн үзүүлэлт тодорхойлоход статистик үзүүлэлтүүд нь цаг хугацааны хувьд хэт хоцорч гарч байна. Мөн үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд хэрэгжүүлж байгаа эргэ хэмжээний нөлөөллийг тооцох судалгааны ажлыг тухай бүр сайн хийж байх хэрэгтэй байна.

Аргачлал: (Тайлант он хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл-Өмнөх оны хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл) / (Өмнөх оны хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл) *100%

Зураг 7. “Малын гоц халдварт өвчний гаралт өмнөх оноос 20-оос доошгүй хувиар буурах тохиолдлын тоо”-гүйцэтгэл



Ахиц дэвшил: 2022-2023 онд шүлхий, бог малын мялзан, үхрийн арьс товруутах, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг тархварзүйн судалгаа, эрсдэлд суурилсан, нэгдсэн болон аян хэлбэрээр зохион байгуулсны үр дүнд өвчний голомтын тоог өмнөх оноос бууруулсан үр дүнд хүрсэн (Дээрх 4 төрлийн гоц халдварт өвчний голомтын тоог өмнөх оноос 494-өөс 192 хүртэл бууруулсан). Тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах хүчин зүйлүүд нөлөөлсөн. Үүнд:

1. МААЭЗЭН төслийн хүрээнд шүлхийгээс сэргийлэх 6,9 тэрбум төгрөгийн өртөг бүхий 6,5 сая тун вакциныг 2022 онд худалдан авч нөөц бүрдүүлснээр 2023 оны хаврын дархлаажуулалтыг шуурхай зохион байгуулсан.
2. ОУ-ын цөмийн энергийн тусламжаар үхрийн арьс товруутахаас сэргийлэх 643,0 сая төгрөгийн өртөг бүхий 500,0 мянган тун вакциныг хүлээн авч ялаа, шумуулын нислэг эхлэхээс өмнө (4-р сард) эрсдэл бүхий зүүн бүсийн аймгуудын үхрийг дархлаажуулснаар өвчин гарахаас сэргийлсэн.
3. Эрсдэл бүхий бүс нутгийн өвчинд хамгийн их мэдрэг, халдвар тархаах хамгийн өндөр эрсдэлтэй мал сүргийг хамруулан, вакцины нөөцөд тусгаарлан, бусад салбарын байгууллага, орон нутгийн удирдлага, малчид иргэдийн оролцоог ханган аян хэлбэрээр зохион байгуулсан зэрэг хүчин зүйл нөлөөлсөн.

Хүндрэл, бэрхшээл: Малын тооны өсөлт, нүүдлийн мал аж ахуйн онцлог, өвчний тархварзүйн нөхцөл байдалд үндэслэн төлөвлөсөн арга хэмжээг бүрэн (мэдрэмтгий мал сүргийг бүрэн хамруулж чадаагүйгээс) хэрэгжүүлээгүйгээс өвчний гаралт дахин дэгдэх, олон аймаг, сумыг хамран, олон тооны мал өвчлөх эрсдэлийг бий болгох бөгөөд дотоод болон гадаад худалдаанд сөргөөр нөлөөлнө.


Аргачлал: (Өмнөх оны малын гоц халдварт өвчин гаралтын тоо - Тайлант оны малын гоц халдварт өвчин гаралтын тоо) / Өмнөх оны малын гоц халдварт өвчин гаралтын тоо*100%




“Газар тариалан” хөтөлбөрийн үр дүнгийн тайлан

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд “Газар тариалан” хөтөлбөрийн нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнгийн дараах гурав (3) шалгуур үзүүлэлт батлагдсан.

Зураг 8. “Газар тариалан” хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Зураг 9. “Үр тариа (цн/га)”-ийн гүйцэтгэл




Ахиц дэвшил: Ахиц дэвшил: 2023 онд улсын хэмжээгээр 369.3 мянган га-д үр тариа, үүнээс 345.4 мянган га-д улаан буудай тариалалт хийж Ургацын урьдчилсан балансаар 510.0 мянган тонн үр тариа, үүнээс 480.0 мянган тонн улаан буудай хураах буюу нэгжээс 15.4 ц/га хураах төлөв гарсан. 2022 оны оноос улаан буудайн ургац 70.0 мянган тонн буюу 17.0 хувиар, нэгжийн 3.9 цн/га-аар буюу 30 гаруй хувь өсөхөөр байна. Нэгжийн ургац өсөхөд дараах хүчин зүйлүүд голчлон нөлөөлсөн. Үүнд:

1. “Хүнсний хангамж, аюулгүй байдал Үндэсний хөдөлгөөн”, Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд арилжааны 10 банкнаас газар тариалангийн үйлдвэрлэгч 631 иргэн аж ахуйн нэгжид 86.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож хаврын тариалалт, уринш боловсруулах, ургамал хамгаалах ажлыг технологийн хугацаанд явуулах, ургац хураалтын бэлтгэл ажлыг хангах боломжийг бүрдүүлсэн.
2. Мөн хөрөнгө оруулалтын зээлийн эх үүсвэрээр 202 иргэн, аж ахуйн нэгжид 5 жилийн хугацаатай, жилийн 6 хувийн хүүтэй 109.4 тэрбум төгрөгийн зээлийг зоорь, хүлэмжийн аж ахуй, услалтын систем, үтрэм байгуулах, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлд зориулан олгосон.
3. Хаврын тариалалтад зориулан 382 аж ахуйн нэгж, иргэнд импортын элит үр 5.6 мянган тонн, дотоодын үржүүлгийн үр 6.4 мянган тонн, нийтдээ 12.0 мянган тонн улаан буудайн үрийг 30 хувийн урьдчилгаа төлбөртэйгөөр олгож тариалалтад дэмжлэг үзүүлж, үрийн шинэчлэл хийсэн.
4. Тариалангийн талбайд хэрэглэсэн бордооны 30 хувийг төрөөс буцаан олгосон.

Хүндрэл, бэрхшээл: 2023 оны нэгжийн ургац, тариалсан талбайн хэмжээ өсөлттэй байгаа хэдий ч тариалангийн зүүн, баруун бүсэд тохиолдсон байгаль цаг, уурын хүндрэлтэй байдал, ургамал хамгааллын бодис бордооны хэрэглээ төлөвшөөгүй, техник технологи, үрийн шинэчлэл хийх шаардлагатай байна.

Аргачлал: = Хураасан үр тариа ургацын хэмжээ/ургацыг тариалсан талбай

Зураг 10. Төмс (цн/га)-ний гүйцэтгэл

Ахиц дэвшил: А2023 онд улсын хэмжээгээр 18.4 мянган га-д төмсний тариалалт хийж Ургацын урьдчилсан балансаар 165.0 мянган тонн төмс буюу нэгжээс 90.2 ц/га хураах төлөв гарсан. 2022 оны оноос тариалах талбайн хэмжээ нэмэгдсэн ч хураан авах ургацын хэмжээ буурсан байна. Төмсний хураан авах ургацын хэмжээ буурсан нь төмсний өвчлөл гарсан холбогдуулан нэгжээс авах ургацын хэмжээ эрс буурсан байна.

Хүндрэл, бэрхшээл: : 2023 онд төмсний хураан авах ургацын бууралтад төмсний өвчлөл голлон нөлөөлсөн бөгөөд ургамал хамгааллын бодис, бордооны зохистой хэрэглээ дутмаг, үрийн шинэчлэл хийгдээгүй, үрийн төмс хадгалах стандарт шаардлага хангасан зоорь, агуулах дутагдалтай байна.

Аргачлал: : Хураасан төмсний ургацын хэмжээ/ ургацыг тариалсан талбай.

Зураг 11. Хүнсний ногоо (цн/га)

Ахиц дэвшил: 2023 онд улсын хэмжээгээр 13.9 мянган га-д төмсний тариалалт хийж Ургацын урьдчилсан балансаар 165.0 мянган тонн төмс буюу нэгжээс 123.0 ц/га хураах төлөв гарсан. 2022 оны оноос ургацын хэмжээ хүнсний ногооны үйлдвэрлэл 25.7 мянган тонн буюу 18.3 хувиар нэмэгдээд байна. Хүнсний ногооны тариалах талбай хураан авах ургацын хэмжээ өсөхөд дараах зүйлүүд голчлон нөлөөлсөн байна.

Үүнд:

1. Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийтдээ 4.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 12 нэр төрлийн ил талбайн болон хүлэмжийн ногооны үрийг нийлүүлж, Засгийн газрын шийдвэрийн дагуу үнийг хөнгөлөн аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газруудаар дамжуулан иргэд, ногоочдод технологийн хугацаанд олгох ажлыг зохион байгуулсан.
2. “Хүнсний хангамж, аюулгүй байдал Үндэсний хөдөлгөөн”, Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд арилжааны 10 банкнаас жимс, хүнсний ногооны тариалан эрхлэгч 544 иргэн аж ахуйн нэгжид 21.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож хаврын тариалалт, уринш боловсруулах, ургамал хамгаалах ажлыг технологийн хугацаанд явуулах, ургац хураалтын бэлтгэл ажлыг хангах боломжийг бүрдүүлсэн.
3. Зах зээлд борлуулсан хүнсний ногооны 1 тонн тутамд 100.0 мянган төгрөгийн урамшуулал олгож байна.

Хүндрэл, бэрхшээл: 2023 онд өмнөх оноос тариалсан талбайн хураан авсан ургацын хэмжээ тогтвортой өсөж байгаа хэдий хаврын тариалалтад шаардагдах хүнсний ногооны үр дутагдалтай, нэр төрөл цөөн, хураан авсан ургац хадгалах зоорь, агуулахын багтаамж дутагдалтай, механикжуулалтын түвшний 50 гаруй хувь нь байгаль цаг уураас хараат байгаа нь өссөн нэмэгдэх хүн амыг хэрэгцээг хангахад хүндрэлтэй байна.

Аргачлал: Хураасан хүнсний ногооны хэмжээ / ургацыг тариалсан талбай.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд “Газар тариалан” хөтөлбөрийн нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнгийн дараах гурав (3) шалгуур үзүүлэлт батлагдсан.

Зураг 12. “Нийт хураан авсан улаан буудайнаас стандартад нийцсэн хувь”-ний гүйцэтгэл



Ахиц дэвшил: : 2023 онд улсын хэмжээгээр 369.3 мянган га-д үр тариа, үүнээс 345.4 мянган га-д улаанбуудай тариалалт хийж Ургацын урьдчилсан балансар 510.0 мянган тонн үр тариа, үүнээс 480.0 мянган тонн улаан буудай хураах буюу нэгжээс 15.4 ц/га хураах төлөв гарсан. 2022 оны оноос улаан буудайн ургац 70.0 мянган тонн буюу 17.0 хувиар, нэгжийн 3.9 цн/га-аар буюу 30 гаруй хувь өсөхөөр байна.

Хүндрэл, бэрхшээл: Байгаль, цаг уурын таагүй үзэгдэл.

Аргачлал: Стандартад нийцсэн улаан буудай/ нийт хураан авсан улаан буудай*100%

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд “Газар тариалан” хөтөлбөрийн төмс, хүнсний ногооны дотоодын хангамжийн хувийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнгийн дараах хоёр (2) шалгуур үзүүлэлт батлагдсан.

Зураг 13. Хүнсний ногооны дотоодын хангамжийн хувь




Ахиц дэвшил: 2023 онд улсын хэмжээгээр 13.9 мянган га-д төмсний тариалалт хийж Ургацын урьдчилсан балансаар 165.0 мянган тонн төмс буюу нэгжээс 123.0 ц/га хураах төлөв гарсан. 2023 оны хэрэгцээт хүнсний ногооны 81.3 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангахаар байна. Хүнсний ногооны тариалах талбай хураан авах ургацын хэмжээ өсөхөд дараах зүйлүүд голчлон нөлөөлсөн байна. Үүнд.

1. Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийтдээ 4.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 12 нэр төрлийн ил талбайн болон хүлэмжийн ногооны үрийг нийлүүлж, Засгийн газрын шийдвэрийн дагуу үнийг хөнгөлөн аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газруудаар дамжуулан иргэд, ногоочдод технологийн хугацаанд олгох ажлыг зохион байгуулсан.
2. “Хүнсний хангамж, аюулгүй байдал Үндэсний хөдөлгөөн”, Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд арилжааны 10 банкнаас жимс, хүнсний ногооны тариалан эрхлэгч 544 иргэн аж ахуйн нэгжид 21.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож хаврын тариалалт, уринш боловсруулах, ургамал хамгаалах ажлыг технологийн хугацаанд явуулах, ургац хураалтын бэлтгэл ажлыг хангах боломжийг бүрдүүлсэн.
3. Зах зээлд борлуулсан хүнсний ногооны 1 тонн тутамд 100.0 мянган төгрөгийн урамшуулал олгож байна.

Хүндрэл, бэрхшээл: 2023 онд өмнөх оноос тариалсан талбайн хураан авсан ургацын хэмжээ тогтвортой өсөж байгаа хэдий хаврын тариалалтад шаардагдах хүнсний ногооны үр дутагдалтай, нэр төрөл цөөн, хураан авсан ургац хадгалах зоорь, агуулахын багтаамж дутагдалтай, механикжуулалтын түвшний 50 гаруй хувь, байгаль цаг уураас хараат байгаа нь өссөн нэмэгдэх хүн амыг хэрэгцээг хангахад хүндрэлтэй байна.

Аргачлал: Үндэсний статистикийн хорооноос гаргасан тухайн жилийн жишсэн хүн амын тоог*260гр*365 килограмм тоннд шилжүүлэн тооцно. (81.3%)

Зураг 14. Төмсний дотоодын хангамжийн хувь

Ахиц дэвшил: 2023 онд улсын хэмжээгээр 18.4 мянган га-д төмсний тариалалт хийж Ургацын урьдчилсан балансаар 165.0 мянган тонн төмс буюу нэгжээс 90.2 ц/га хураах төлөв гарсан. 2022 оны оноос тариалах талбайн хэмжээ нэмэгдсэн ч хураан авах ургацын хэмжээ буурсан байна. Төмсний хураан авах ургацын хэмжээ буурсан нь төмсний өвчлөл гарсан холбогдуулан нэгжээс авах ургацын хэмжээ эрс буурсан байна.

Хүндрэл, бэрхшээл: 2023 онд төмсний хураан авах ургацын бууралтад төмсний өвчлөл голлон нөлөөлсөн бөгөөд ургамал хамгааллын бодис, бордооны зохистой хэрэглээ дутмаг, үрийн шинэчлэл хийгдээгүй, үрийн төмс хадгалах стандарт шаардлага хангасан зорь, агуулахын багтаамж дутагдалтай байна.

Аргачлал: Үндэсний статистикийн хорооноос гаргасан тухайн жилийн жишсэн хүн амын тоог*120гр*365 килограмм тоннд шилжүүлэн тооцно. (81.3%)


Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн үр дүнгийн тайлан

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд “Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх” хөтөлбөрийн мах, сүү бэлтгэлийн улирлын хэлбэлзэл бууруулах чиглэлээр үр дүнгийн дараах хоёр (2) шалгуур үзүүлэлт батлагдсан.

Зураг 15. “Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх” хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Зураг 16. Нийлүүлсэн түүхий сүү (сая литр)-ний гүйцэтгэл




Ахиц дэвшил: Сүүний урамшуулал өгч эхлээгүй өвлийн улиралд 6.8 сая литр түүхий сүү нийлүүлж байсан бол сүүний урамшуулал өгснөөр сүүлийн 3 жилийн дунджаар жилд 10.3 сая литр стандартын шаардлага хангасан түүхий сүүг үйлдвэрт нийлүүлж, түүхий сүүний нийлүүлэлт 51.5 хувиар нэмэгдсэн.

Хүндрэл, бэрхшээл: Өвлийн улирлын сүүний нийлүүлэлтийг тогтвортой байлгах үүднээс 5 сарын хугацаанд сүүний урамшууллыг малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд олгодог. Сүүний урамшууллын дүнг холбогдох тооцоо, судалгаа хийсний үндсэн дээр мөнгөн дүнг тооцож гаргадаг бөгөөд үр дүнг тооцолгүйгээр урамшууллын дүнг хасаж байгаа нь дараах сөрөг үр дагаврыг үүсгэж байна. Тухайлбал: үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ багасаж, сүүн бүтээгдэхүүний хангамжийн хувь буурч байгаа нь бодлогын баримт бичигт тусгагдсан холбогдох үзүүлэлтэд хүрэхгүй зэрэг томоохон өөрчлөлтүүд гарч байна.

Аргачлал: = нийлүүлсэн түүхий сүү /сая литр/

Зураг 17. Нийлүүлсэн түүхий сүү (сая литр)-ний гүйцэтгэл



Ахиц дэвшил: Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.

Хүндрэл, бэрхшээл: Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах хүндрэл бэрхшээл гарч байсан. Үүнд:


- Эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад орчны төлөв, эрсдэлээс хамаарч бодлогын хүү нэмэгдэх
- Дээрх нөхцөл байдлаас хамаарч зээлийн хүүгийн хөнгөлөлт өөрчлөлт орох, улсын төсөвт дарамт үүсэх нөхцөл ажиглагдаж байна.

Аргачлал: = бэлтгэж, борлуулсан махны хэмжээ /мян.тн/

Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийн үр дүнгийн тайлан

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд **“Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх”** чиглэлээр үр дүнгийн дараах хоёр (2) шалгуур үзүүлэлт батлагдсан.

Зураг 18. “Хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх” хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Зураг 19. “Дархан арьс ширний цогцолбор” УТП-ын дэд бүтэц, үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын хувь




Ахиц дэвшил: Засгийн газрын 2022 оны 09 дүгээр тогтоолоор Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтад шаардлагатай Монголын талаас гаргах 50.0 (тавин) тэрбум төгрөгийг нийгмийн хариуцлагын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөрөнгөөр зохих журмын дагуу санхүүжүүлэхээр шийдвэрлэсний дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх үйл ажиллагааг зохицуулах түр журмыг 2022.05.17-ны өдөр Сангийн яам, ХХААХҮЯ болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ хамтран баталсан. Тус түр журмын дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас санхүүжих Үйлдвэрийн барилгын зураг төсөл гүйцэтгэгчийн эхлэлтийн тайлангийн санхүүжилт болох гэрээний үнийн дүнгийн 30 хувь буюу 318.6 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч компаниудад олгож, ажилд хяналт тавин ажиллаж байна.

Хүндрэл, бэрхшээл: “Дархан арьс ширний цогцолбор” ХХК болон “Монгол Улсын Хөгжлийн банк” хооронд дэд бүтцийн бүтээн байгуулалтын эцсийн өмчлөгчийн асуудлыг шийдвэрлэсний дараа хамтран ажиллахад бэлэн байгаа тухай ХХААХҮ-ийн сайдын 2023.08.03-ны өдрийн 01/2715 дугаар албан бичгийг “ДАШЦ” ХХК-д хүргүүлсэн.

Санал: 2024 оны төсвийн төсөлд санхүүжилтийг тусгах.

Зураг 20. “Шинэ Ховд” УТП-ын дэд бүтцийн бүтээн байгуулалтын явцын хувь



Ахиц дэвшил: Өнгөрсөн онд Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн парк дэд бүтцийн зураг төсөв боловсруулахад зориулж 665 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд энэ онд 5.9 тэрбум төгрөгийг дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд тусгасан.


Хүндрэл, бэрхшээл: Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу энэ онд бүтээн байгуулалтын ажлыг 90 хувьд хүргэхээр төлөвлөж байсан боловч Улсын төсөвт тусгагдсан санхүүжилтээс шалтгаалан бүтээн байгуулалтын ажил хойшлогдоод байна.


Санал: 2024 оны төсвийн төсөлд санхүүжилтийг тусгах.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн үр дүнгийн тайлан

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд **“Жижиг дунд үйлдвэрийг дэмжих”** чиглэлээр үр дүнгийн дараах нэг (1) шалгуур үзүүлэлт батлагдсан.

Зураг 21. “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих” хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Зураг 22. Идэвхтэй жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн тоо

Ахиц дэвшил: : 2021 оны байдлаар Үндэсний статистикийн хорооноос авсан мэдээллээр Жижиг дунд үйлдвэр эрхлэгчийн тоо 53931 байсан. 2022 оны салбарын мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос хараахан гаргаагүй байна.

Хүндрэл, бэрхшээл: Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн үр дүнг хагас жил тутамд дүгнэх нь учир дутагдалтай гэж үзэж байна. Учир нь Үндэсний статистикийн хорооны мэдээлэл нь жилд нэг л удаа гардаг.

Аргачлал: Идэвхтэй бизнес эрхлэгч жижиг дунд үйлдвэрлэгчдийн тоо.

Санал: Шалгуур үзүүлэлтийн үр дүнг салбарт олгосон санхүүжилтийн үр дүнд шинээр бий болсон ажлын байрны тоогоор хэмжих саналтай байна.

ТХЗ-ийн үр дүнгийн тайлан

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд Тогтвортой хөгжлийн зорилтууд түүний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангах дараах хөтөлбөр багтсан.

Хүснэгт 4: 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулах нь

Тогтвортой хөгжлийн зорилт		
Тогтвортой хөгжлийн зорилт	Тогтвортой хөгжлийн зорилт	
Зорилго 2 Өлсгөлөнг эцэс болгож, хүнсний аюулгүй байдлыг хангаж, хоол тэжээлийн байдлыг сайжруулж, тогтвортой хөдөө аж ахуйг хөхүүлэн дэмжих	Зорилт 2.1. 2030 он гэхэд ядуурлыг эцэс болгож, хүн бүрийг, ялангуяа ядуу болон эмзэг бүлгийн хүмүүс, түүний дотор нялхсыг эрүүл, шим тэжээллэг, хүрэлцэхүйц хоол хүнсийг жилийн турш авах боломжоор хангах	
	Зорилт 2.5. 2030 он гэхэд олон улс, бүс нутаг, үндэсний түвшний зохистой удирдлага, зохион байгуулалттай, олон төрлийн үр, ургамлын сантай банкаар дамжуулан үр, тариалах ургамал, фермерийн болон гэрийн тэжээвэр амьтан, тэдгээртэй холбоотой зэрлэг ан амьтдын генетикийн олон янз байдлыг хадгалж, олон улсын хэмжээнд тохиролцсоны дагуу генетикийн нөөц баялаг, уламжлалт холбогдох мэдлэгийг ашигласнаар гарах үр шимийг хүртэх, эрх тэгш, шударга зарчмаар солилцох нөхцөлийг бүрдүүлэх	
Зорилго 8. Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих	Зорилт 8.3 Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдал, инновацийг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих	
Зорилго 9. Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх	Зорилт 9.2 Хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэржилтийг хөхүүлэн дэмжиж, 2030 он гэхэд үндэсний нөхцөл байдалтай уялдуулан ДНБ-нд аж үйлдвэрийн салбарын ажлын байрны эзлэх хувийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, нэн буурай хөгжилтэй орнуудад энэ хувийг хоёр дахин өсгөх	
	Зорилт 9.б Бодлогын таатай орчныг хангах, тухайлбал аж үйлдвэрийн төрөлжилт, бараа бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх замаар хөгжиж буй орнуудын дотоодын технологийн хөгжил, судалгаа шинжилгээ, инновацийг дэмжих	
	Зорилт 9.3 Жижиг хэмжээний аж үйлдвэрийн болон бусад салбарын аж ахуй нэгжүүд, ялангуяа хөгжиж буй орнуудын эдгээр аж ахуй нэгжүүдийн санхүүгийн үйлчилгээ авах, түүний дотор хямд зээл авах, үйлдвэрлэл, зах зээл нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх	
Зорилго 12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих	Зорилт 12.3 2030 он гэхэд жижиглэн худалдааны болон хэрэглээний түвшинд нэг хүнд ногдох дэлхийн хүнсний хаягдлыг хоёр дахин багасгаж, үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн тогтолцоотой холбоотойгоор гарах хүнсний алдагдал, түүний дотор ургац хураалтын дараах алдагдлыг бууруулах	



	2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралт		2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэл сая төгрөг
	Хөтөлбөр	Хөтөлбөрийн хүрэх үр дүн	
	Мал аж ахуйг хөгжүүлэх	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бодит өсөлтийн хувь	1.437,7
		Малын гоц халдварт өвчний гаралт өмнөх оноос 20-оос доошгүй хувиар буурах тохиолдлын тоо	
	Газар тариалан хөгжүүлэх	Нийт хураан авсан улаан буудайнаас стандартад нийцсэн хувь	35.568,4
	Мал аж ахуйг хөгжүүлэх	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бодит өсөлтийн хувь	2.177,2
		Малын гоц халдварт өвчний гаралт өмнөх оноос 20-оос доошгүй хувиар буурах тохиолдлын тоо	
	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	Идэвхтэй жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн тоо	0
	Газар тариалан хөгжүүлэх	Нийт хураан авсан улаан буудайнаас стандартад нийцсэн хувь	15.5
	Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх	Нийт хураан авсан улаан буудайнаас стандартад нийцсэн хувь	45,5
		Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв	
	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	Идэвхтэй жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн тоо	921,8
	Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Хүнсний хангамж, аюулгүй байдал, хяналтын судалгаа	3,0

Дүгнэлт, санал

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд ХХААХҮ-ийн сайдын багцад 5 хөтөлбөрийн 13 шалгуур үзүүлэлт батлагдсан.

ХХААХҮ-ийн сайдын 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэлээр Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системээс 8 хөтөлбөрийн гүйцэтгэл гарчээ. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт тогтоогоогүй дараах 3 хөтөлбөрт батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэл гарсан.

- Мэргэжлийн хяналт,
- Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага,
- Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ

Үүнээс Мэргэжлийн хяналт, Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ гэсэн 2 хөтөлбөрийн гүйцэтгэлийг хүрэх үр дүн тодорхойлсон 5 хөтөлбөрт хуваарилсан. ХХААХҮ-ийн сайдын багцын нийт зардлын 41.2 хувь 54,430.7 сая төгрөгийг Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага хөтөлбөрт зарцуулсан боловч уг зардлыг хүрэх үр дүн тодорхойлсон 5 хөтөлбөрт хуваарилах боломжгүй байлаа. Иймд бодлогын хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусад нь тодорхойлох эсвэл хамаарах хөтөлбөрүүдэд үр дүн, төсвийг хуваарилах нь зүйтэй.

Мал аж ахуй хөгжүүлэх хөтөлбөр

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бодит өсөлтийн хувь шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн мэдээлэл тухайн ондоо багтаж үр дүнг гаргах боломжгүй албан ёсны статистик мэдээлэл 2 жилийн дараа гарах боломжтой шалгуур үзүүлэлт тогтоосон.

Газар тариалан хөгжүүлэх хөтөлбөр

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг батлагдсан төсөвтэй уялдуулан тохируулга хийгээгүй нь тус хөтөлбөрийн үр дүнд нөлөөлсөн. Мөн

- нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэх чиглэлээр 3,
- стандартын шаардлага хангасан ургацыг нэмэгдүүлэх чиглэлээр 1,
- төмс, хүнсний ногооны дотоодын хангамжийн хувийг нэмэгдүүлэх чиглэлээр

нийт 6 шалгуур үзүүлэлт батлагдсанаас “Үр тариа (цн/га)”-ийн гүйцэтгэл, “Нийт хураан авсан улаан буудайнаас стандартад нийцсэн хувь”-ний гүйцэтгэлийн үр дүн нэг үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт давхардуулан сонгосон. Мөн төмс (цн/га)-ний гүйцэтгэл, төмсний дотоодын хангамжийн хувь болон хүнсний ногоо (цн/га), хүнсний ногооны дотоодын хангамжийн хувь гэсэн шалгуур үзүүлэлт нь нэг ижил үл дүнг хангах шалгуур үзүүлэлтийг тогтоосон байна.

Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр

Тухайн хөтөлбөрийн 2 шалгуур үзүүлэлтийн хөтөлбөрийн гүйцэтгэл, үр ашгийн гүйцэтгэл хэт өндөр буюу хүлээн зөвшөөрөгдөх хэлбэлзлийн хувиас (10%) хэт өндөр байгаа нь зорилтот түвшинг анх тогтоохдоо жинлэсэн дундаж хүн амын хэрэгцээ зэрэг мэдээлэлд үндэслэн тогтоосон эсэх, мөн цаашид батлагдсан төсвөөс төдийлөн хамааралтай биш үр дүн нь тогтмол гардаг шалгуур үзүүлэлтүүдийг тусад нь авч үзэх нь зүйтэй байна. Батлагдсан төсөвтэй харьцуулахад үр дүнгийн гүйцэтгэл өндөр байгааг тодорхойлж зорилтот түвшинг сүүлийн жилийн өсөлтийн дундаж хувь зэрэг үзүүлэлтэд үндэслэн бодитой тооцох нь зүйтэй.


Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг батлагдсан төсөвтэй уялдуулан тохируулга хийгээгүй нь тус хөтөлбөрийн үр дүнд нөлөөлсөн. Мөн төсвийн тодотголоор уг хөтөлбөрийн батлагдсан төсөв буурсан.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих


Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо үр дүнгийн мэдээлэл дотоодоос гарах эсэх Үндэсний статистикийн хороо гэх мэт мэдээллийн нэгдсэн сангаас гарах бол тухайн мэдээлэл жилдээ багтаж гарах эсэхийг харгалзан үзэх шаардлагатай байна. “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн үр дүнг салбарт олгосон санхүүжилтийн үр дүнд шинээр бий болсон ажлын байрны тоогоор хэмжих саналаа 2024 оны төсвийн төсөлд тусган ажиллажээ.

Зураг 23. ХХААХҮ-ийн сайдын 2023 оны эхний хагас жилийн хөтөлбөрийн гүйцэтгэл



Графикаас харахад Мал аж ахуй хөгжүүлэх, Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн гүйцэтгэл хэт өндөр байгаа нь эхний хагас жилийн батдагдсан төсвөөр уг зорилтот түвшинд хүрэх боломжтой байгаа мэт харагдаж байгаа ч хөтөлбөр бүрийн үр дүн гарах хугацаа, улирал нь өөр тул тогтоосон зорилтот түвшинг хагас, бүтэн жилээр төлөвлөж өгөх нь үр дүнгийн тайлан үнэн, зөв гарах үндэс болох билээ. Мөн тухайн хөтөлбөрийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг зөв тогтоож, тогтвортой байлгах нь шалгуур үзүүлэлтийн өсөлт бууралтыг тооцох, бусад жилүүдтэй харьцуулж үр дүнг бодитой хэмжих боломж бүрдүүлэх юм.

Зураг 24. ХХААХҮ-ийн сайдын 2023 оны эхний хагас жилийн хөтөлбөрийн гүйцэтгэлийн үр ашиг



Мал аж ахуйг хөгжүүлэх, Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн үр ашиг хүлээн зөвшөөрөгдөх хэлбэлзлээс хэт өндөр байгаа нь батлагдсан төсөв, гүйцэтгэл 2023 оны хагас жилээр, хүрсэн түвшний үзүүлэлт урьдчилсан болон хүлээгдэж буй гүйцэтгэлээр тайлагнасангай холбоотой.

Эцэст нь тус яамны үр дүнг тайлагнахтай холбоотой нийтлэг гарч байгаа дутагдал нь сонгож авсан шалгуур үзүүлэлт нь тухайн хөтөлбөрийн гол үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт төдийлөн биш байна. Хөтөлбөрийн үр дүнг зөв тодорхойлсон боловч шалгуур үзүүлэлтийг зөв тогтоох, одоо тооцогдохгүй байгаа шалгуур үзүүлэлтүүдийг шинээр гаргаж хөтөлбөрийн үр дүнг бүрэн илэрхийлэх зөв шалгуур үзүүлэлтийг тогтоох нь зүйтэй байна.

Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Суурь он	Суурь түвшин	2024 оны зорилтот түвшин	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	
Мал аж ахуй хөгжүүлэх	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бодит өсөлтийн хувь	2021	5.5	4.5	2,194,0	1,094,7	
	Малын гоц халдварт өвчний гаралт өмнөх оноос 20-оос доошгүй хувиар буурах тохиолдлын тоо	2022	494	370	48,705,2	42,825,4	
Газар тариалан хөгжүүлэх	Үр тариа (цн/га)	2021	13.4	14	30,700,0	30,208,6	
	Төмс (цн/га)	2021	126.9	130	500,0	500,0	
	Хүнсний ногоо (цн/га)	2021	117.4	200	4,180,0	4,180,0	
	Нийт хураан авсан улаан буудайнаас стандартад нийцсэн хувь	2021	65	70	14,000,0	13,024,7	
	Хүнсний ногооны дотоодын хангамжийн хувь	2021	70	75	4,500,0	4,377,4	
	Төмсний дотоодын хангамжийн хувь	2021	100	100	500,0	308,6	
Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Нийлүүлсэн түүхий сүү /сая литр/	2022	19.5	22	4,788,4	4,788,4	
	Бэлтгэж, борлуулсан махны хэмжээ /мян.тн/	2022	7.4	15	1,756,7	1,756,7	
Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх	"Дархан арьс ширний цогцолбор" УТП-ын дэд бүтэц, үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын хувь	2022	20	60	-		
	"Шинэ Ховд" УТП-ын дэд бүтцийн бүтээн байгуулалтын явцын хувь	2022	30	90	-		
Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	Идэвхтэй жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн тоо	2022	64,252	65,000,0	25,921,3		
Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага							
					170,545,4	132,065,1	

ХӨТӨЛБӨРТ ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	Төсвийн гүйцэтгэлийн %	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь	Тайлбар
	49.90%	12	267%	ХААХҮ-ийн салбарын бодлого, хууль эрх зүйн шинэчлэл, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөөг илэрхийлэх нэгдсэн үр дүнг дээрх үзүүлэлтээр тодорхойлсон ба 2023 оны эхний хагас жилийн байдлаар 12 хувийн өсөлттэй байна. Дээр өсөлтөд 2023 онд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн шинэчлэл, гааль, НӨАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт болон Засгийн газраас 13 хувийг хариуцан төлөх нөхцөлтэй хөтөлбөрийн зээлүүд голчлон нөлөөлсөн.
	87.93%	192	193%	2022-2023 онд шүлхий, бог малын мялзан, үхрийн арьс товруутах, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг тархварзүйн судалгаа, эрсдэлд суурилсан, нэгдсэн болон аян хэлбэрээр зохион байгуулсны үр дүнд өвчний голомтын тоог өмнөх оноос бууруулсан үр дүнд хүрсэн (Дээрх 4 төрлийн гоц халдварт өвчний голомтын тоог өмнөх оноос 494-өөс 192 хүртэл бууруулсан).
	98.40%	15.1	108%	2023 онд улсын хэмжээгээр 369.3 мянган га-д үр тариа, үүнээс 345.4 мянган га-д улаан буудай тариалалт хийж Ургацын урьдчилсан балансаар 510.0 мянган тонн үр тариа, үүнээс 480.0 мянган тонн улаан буудай хураах буюу нэгжээс 15.4 ц/га хураах төлөв гарсан.
	100.00%	90.2	69%	2023 онд улсын хэмжээгээр 18.4 мянган га-д төмсний тариалалт хийж Ургацын урьдчилсан балансаар 165.0 мянган тонн төмс буюу нэгжээс 90.2 ц/га хураах төлөв гарсан.
	100.00%	123.0	62%	2023 онд улсын хэмжээгээр 13.9 мянган га-д төмсний тариалалт хийж Ургацын урьдчилсан балансаар 165.0 мянган тонн төмс буюу нэгжээс 123.0 ц/га хураах төлөв гарсан.
	93.03%	72.3	103%	2023 онд улсын хэмжээгээр 369.3 мянган га-д үр тариа, үүнээс 345.4 мянган га-д улаан буудай тариалалт хийж Ургацын урьдчилсан балансаар 510.0 мянган тонн үр тариа, үүнээс 480.0 мянган тонн улаан буудай хураах буюу нэгжээс 15.4 ц/га хураах төлөв гарсан.
	97.28%	73.0	97%	2023 онд улсын хэмжээгээр 13.9 мянган га-д төмсний тариалалт хийж Ургацын урьдчилсан балансаар 165.0 мянган тонн төмс буюу нэгжээс 123.0 ц/га хураах төлөв гарсан.
	61.72%	100.0	100%	2023 онд улсын хэмжээгээр 18.4 мянган га-д төмсний тариалалт хийж Ургацын урьдчилсан балансаар 165.0 мянган тонн төмс буюу нэгжээс 90.2 ц/га хураах төлөв гарсан.
	100.00%	113.6	516%	Сүүний урамшуулал өгч эхлээгүй өвлийн улиралд 6.8 сая литр түүхий сүү нийлүүлж байсан бол сүүний урамшуулал өгснөөр сүүлийн 3 жилийн дунджаар жилд 10.3 сая литр стандартын шаардлага хангасан түүхий сүүг үйлдвэрт нийлүүлж, түүхий сүүний нийлүүлэлт 51.5 хувиар нэмэгдсэн.
	100.00%	19.9	133%	Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.
		0.0	0%	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас санхүүжих Үйлдвэрийн барилгын зураг төсөл гүйцэтгэгчийн эхлэлтийн тайлангийн санхүүжилт болох гэрээний үнийн дүнгийн 30 хувь буюу 318.6 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч компаниудад олгож, ажилд хяналт тавин ажиллаж байна.
		17.0	19%	Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн парк дэд бүтцийн зураг төсөв боловсруулахад зориулж 665 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд энэ онд 5.9 тэрбум төгрөгийг дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд тусгасан.
	0.00%		0%	2021 оны байдлаар Үндэсний статистикийн хорооноос авсан мэдээллээр Жижиг дунд үйлдвэр эрхлэгчийн тоо 53931 байсан. 2022 оны салбарын мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос хараахан гаргаагүй байна.
				Үр дүн тодорхойлоогүй.

